



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/338

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Соёлын өвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3, 16.1.6, Засгийн газрын 2003 оны 190 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутагт орших Уушгийн өврийн буган чулуун дурсгалыг дэлхийн соёлын өвд бүртгүүлэхтэй холбоотой хамгаалалтын бүсэд баригдсан барилга байгууламжийг шилжүүлэхтэй холбоотой асуудлыг судалж, зохион байгуулалттай холбоотой арга хэмжээ авч, үр дүнг танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Батбилгүүн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүдэд:

М.Алтаншагай (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн  
хэлтсийн дарга)

Г.Базар (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн  
хэлтсийн дарга)

Л.Батцэцэг (Аймгийн Соёл урлагийн газрын дарга)

Б.Мөнгөнзул (Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга)

А.Алтанцоож (Аймгийн Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа)

Б.Эрдэнэдалай (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын Газрын  
удирдлагын хэлтсийн дарга)

Ц.Бэхбаяр (Аймгийн Соёл урлагийн газрын Захиргаа, удирдлагын  
хэлтсийн дарга)

Л.Аззаяа (Бүрэнтогтох сумын Засаг дарга)

Д.Дуламсүрэн (Бүрэнтогтох сумын газрын даамал)

Нарийн бичгийн дарга:

Х.Баасансүрэн (Аймгийн Соёл урлагийн газрын Соёл, урлагийн хэлтсийн  
ахлах мэргэжилтэн)

671 010701



2.

2. Бүрэнтогтох сумын Уушгийн өврийн буган чулуун хөшөөний цогцолборын хамгаалалтын бүсэд орших жуулчны баазтай холбоотой нүүлгэн шилжүүлэх саналыг судлан, 2023 оны 6 дугаар сарын 30-ны дотор Засаг даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Батбилгүүн)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д даалгасугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ, ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ

М.ХУЯГБААТАР

